



ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 10 сарын 05 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлд Хувьцаа эзэмшигчийн
төлөөлөл хэрэгжүүлэх гишүүдийг томилох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.2, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 310 дугаар тогтоолын 3 дугаар заалт, 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн, Авлигатай тэмцэх газрын 2023 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 05/14114, 2023 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 05/14745, 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 05/14456, 2023 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 05/14523, 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 05/15084, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн A/158 дугаар тушаал, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 01/1663 тоот албан бичгийг тус тус удирдамж болгон ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 435 дугаар тогтоолын 5-д заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэх хүртэлх хугацаанд “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд Хувьцаа эзэмшигчийн төлөөлөл хэрэгжүүлэгчээр дараах гишүүдийг шинээр сонгосугай. Үүнд:

- 1.1. Машлайн Алтан-Очир
- 1.2. Мягмарын Батмягмар
- 1.3. Түвшингийн Батзориг
- 1.4. Данзан-Яринпилийн Мөнхбат
- 1.5. Даваасүрэнгийн Оюунсүрэн
- 1.6. Батсуурийн Отгонсүх
- 1.7. Нүрэнзэдгомбын Цэрэнсамбуу

2. Энэ тогтоолыг 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ХУРЛЫН ДАРГА *Ц.Мэндбаяр* Ц.МЭНДБАЯР

